**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/26/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он


Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................................................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................................................6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................................................9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................................................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....................................................13
3. Аудитын тайлан....................................................15
3.1 Ерөнхий зүйл....................................................15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................16
3.4 Материаллаг байдал ....................................................16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................................................16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................................................17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................................................19
3.8 Аудитын гол асуудал ....................................................19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................................19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................................................19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................................................20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................................................20
4. Аудитын илрүүлэлт ....................................................20
4.1 Залруулсан алдаа....................................................20
4.2 Төлбөрийн акт....................................................20
Байхгүй ....................................................20
4.3 Албан шаардлага ....................................................20
4.4 Зөвлөмж ....................................................20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................21

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,750,389.00** | **78,682,795.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **80,750,389.00** | **78,682,795.00** |
| **351** | **Түүхий эд материал** | 2,728,500.00 | 1,149,090.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,511,800.00 | 1,084,200.00 |
| 35130 | Эм боох материал | 216,700.00 | 64,890.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 78,021,889.00 | 77,533,705.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,333,570.00 | 980,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 68,309,853.00 | 70,614,742.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 33,000.00 | 141,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | |
| 35460 | Хүнсний материал | 5,246,328.00 | 2,698,125.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,099,138.00 | 3,099,138.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | - |
| 36100 | Барааны нөөц | - | - |
| 36600 | Бусад нөөц | - | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,649,321,223.53** | **1,919,108,749.49** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,649,321,223.53 | 1,919,108,749.49 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,616,455,223.53 | 1,886,242,749.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,590,404,480.13 | 1,842,404,480.13 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (50,696,981.70) | (76,019,120.22) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,410,000.00 | 2,410,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (2,410,000.00) | (2,410,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 128,157,118.04 | 137,725,878.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (123,118,498.11) | (98,961,009.28) |

| | | | |
|---|---|---|---|
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 105,950,517.00 | 106,199,073.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (82,767,980.71) | (77,613,393.78) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 869,632.88 | 869,632.88 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (173,926.56) | (260,889.84) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39217 | Ном | 47,830,862.56 | 51,898,098.56 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 32,866,000.00 | 32,866,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,866,000.00 | 32,866,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,730,071,612.53** | **1,997,791,544.49** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **411** | **Богино хугацаат үнэт цаас** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,730,071,612.53** | **1,997,791,544.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,730,071,612.53 | 1,997,791,544.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 537,366,354.00 | 537,366,354.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 537,366,354.00 | 537,366,354.00 |
| 51102 | - хувийн | - | - |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(348,146,714.21)** | **(80,426,782.25)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (322,133,292.62) | (348,146,714.21) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (26,013,421.59) | 267,719,931.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,540,851,972.74 | 1,540,851,972.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,730,071,612.53** | **1,997,791,544.49** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,205,580,171.04** | **1,525,820,337.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **50,160.00** | **359,754.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 50,160.00 | 359,754.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 50,160.00 | 359,754.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 50,160.00 | 359,754.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,205,530,011.04** | **1,525,460,583.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,051,061,461.04 | 1,377,243,536.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 3,243,611.04 | 294,488,936.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,047,817,850.00 | 1,082,754,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 5,037,047.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,037,047.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 154,468,550.00 | 143,180,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 154,468,550.00 | 143,180,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,231,593,592.63** | **1,258,100,405.04** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,231,593,592.63** | **1,258,100,405.04** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,222,678,892.63 | 1,240,987,544.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 897,524,700.00 | 914,038,919.00 |
| 210101 | Үндсэн цалин | 816,525,700.00 | 860,530,992.00 |
| 210104 | Урамшуулал | 76,461,200.00 | 48,970,127.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,537,800.00 | 4,537,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 118,163,400.00 | 118,490,681.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,151,900.00 | 82,101,881.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,752,900.00 | 9,097,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,002,300.00 | 7,277,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,750,600.00 | 1,819,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,505,700.00 | 18,194,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 154,383,100.00 | 141,696,660.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,068,750.00 | 2,849,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 149,966,400.00 | 137,861,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,347,950.00 | 985,960.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,847,800.00 | 7,685,314.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 549,600.00 | 782,070.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 683,200.00 | 854,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 684,400.00 | 707,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 141,800.00 | 185,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,788,800.00 | 5,156,844.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,978,562.00 | 20,349,213.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 305,970.00 | 245,510.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,339,292.00 | 17,988,503.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,333,300.00 | 2,115,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210604 | Урсгал засвар | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 32,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 32,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 562,170.00 | 927,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 327,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 562,170.00 | 600,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,219,160.63 | 37,767,257.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 490,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 960,630.00 | 4,469,847.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,258,530.63 | 32,807,410.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,914,700.00 | 17,112,861.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,714,700.00 | 16,881,661.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,714,700.00 | 16,881,661.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 200,000.00 | 231,200.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200,000.00 | 231,200.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(26,013,421.59)** | **267,719,931.96** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | - |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(26,013,421.59)** | **267,719,931.96** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **537,366,354.00** | 1,540,851,972.74 | (348,146,714.21) | **1,730,071,612.53** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **537,366,354.00** | **1,540,851,972.74** | **(348,146,714.21)** | **1,730,071,612.53** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | - |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **537,366,354.00** | **1,540,851,972.74** | **(348,146,714.21)** | **1,730,071,612.53** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **537,366,354.00** | **1,540,851,972.74** | **(348,146,714.21)** | **1,730,071,612.53** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **537,366,354.00** | **1,540,851,972.74** | **(348,146,714.21)** | **1,730,071,612.53** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 267,719,931.96 | **267,719,931.96** |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **537,366,354.00** | **1,540,851,972.74** | **(80,426,782.25)** | **1,997,791,544.49** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,202,286,400.00** | **1,230,971,647.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **-** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,202,286,400.00** | **1,230,971,647.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,047,817,850.00 | 1,082,754,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,047,817,850.00 | 1,082,754,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 5,037,047.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,037,047.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 154,468,550.00 | 143,180,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 154,468,550.00 | 143,180,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,200,992,400.00** | **1,222,865,647.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,200,992,400.00** | **1,222,865,647.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,192,077,700.00** | **1,205,551,947.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 897,524,700.00 | 909,717,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 816,525,700.00 | 859,409,400.00 |
| 210104 | Урамшуулал | 76,461,200.00 | 45,770,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,537,800.00 | 4,537,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 118,163,400.00 | 122,812,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,151,900.00 | 86,423,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,752,900.00 | 9,097,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,002,300.00 | 7,277,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,750,600.00 | 1,819,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,505,700.00 | 18,194,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 154,468,550.00 | 142,180,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,002,150.00 | 3,211,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 149,966,400.00 | 137,969,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 1,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,298,100.00 | 3,503,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 766,500.00 | 230,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 683,200.00 | 854,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 894,000.00 | 1,041,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 141,800.00 | 251,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,812,600.00 | 1,127,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 15,056,150.00 | 16,991,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 191,700.00 | 207,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,241,250.00 | 15,440,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,623,200.00 | 1,343,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 32,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 32,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 600,000.00 | 929,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 329,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,966,800.00 | 8,386,447.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 490,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,966,800.00 | 7,896,447.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,914,700.00** | **17,313,700.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,714,700.00 | 17,082,500.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,714,700.00 | 17,082,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 200,000.00 | 231,200.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213502 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200,000.00 | 231,200.00 |
| 213504 | Хөрөнгийн | | |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,294,000.00** | **8,106,000.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 140002 | Улсын төсвөөс олгосон зээл | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,294,000.00** | **8,106,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,294,000.00** | **8,106,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,294,000.00 | 8,106,000.00 |
| 221001 | Их засвар | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,294,000.00 | 8,106,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,294,000.00)** | **(8,106,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | **-** | **-** |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,225,934,600.00** | **1,225,703,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,225,934,600.00** | **1,225,703,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,208,852,100.00** | **1,208,620,900.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 909,717,600.00 | 909,717,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 859,409,400.00 | 859,409,400.00 |
| 210104 | Урамшуулал | 45,770,400.00 | 45,770,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,537,800.00 | 4,537,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 122,812,000.00 | 122,812,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,423,200.00 | 86,423,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,097,200.00 | 9,097,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,277,700.00 | 7,277,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,819,500.00 | 1,819,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,194,400.00 | 18,194,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 142,180,000.00 | 142,180,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,211,000.00 | 3,211,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 137,969,000.00 | 137,969,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,519,500.00 | 7,519,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 230,300.00 | 230,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 854,000.00 | 854,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,041,200.00 | 1,041,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 329,000.00 | 329,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,065,000.00 | 5,065,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 16,991,400.00 | 16,991,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 207,600.00 | 207,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,440,300.00 | 15,440,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,343,500.00 | 1,343,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 263,200.00 | 32,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 263,200.00 | 32,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 929,000.00 | 929,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 329,000.00 | 329,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,439,400.00 | 7,439,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,439,400.00 | 7,439,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,082,500.00 | 17,082,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,082,500.00 | 17,082,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,082,500.00 | 17,082,500.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,225,934,600.00** | **1,225,703,400.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,082,754,600.00** | **1,082,523,400.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,082,754,600.00 | 1,082,523,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 143,180,000.00 | 143,180,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 143,180,000.00 | 143,180,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **69** | **77** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 41 | 45 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 26 | 30 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1 | 1 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 438 | 438 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 438 | 438 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 438 | 438 |
| 630002 | Хувийн ЕБС | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **69** | **77** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 42 | 46 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 26 | 30 |
| 650010 | Гэрээт ажилтан | 1 | 1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **5,037,047.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **5,037,047.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 5,037,047.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 5,037,047.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 490,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 4,547,047.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **-** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **5,037,047.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | 5,037,047.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,037,047.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн №01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургууль нь: сургууль сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу суралцагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт нийцүүлэн өөрийн онцлогийг тусгасан сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах, суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант онд тус анги нь “Чадварлаг үйлчилгээ,чанартай сургалт, бүтээлч суралцагч” гэсэн зорилтын дор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуульд дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1231.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 24.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 267.7 сая төгрөгөөр буюу 15.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс өссөн, үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | | | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 80,750.40 | 78,682.80 | (2,067.60) |
| Үндсэн хөрөнгө | 1,649,321.20 | 1,919,108.70 | 269,787.50 |
| **Нийт хөрөнгө** | **1,730,071.60** | **1,997,791.50** | **267,719.90** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,730,071.60 | 1,997,791.50 | 267,719.90 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,730,071.60** | **1,997,791.50** | **267,719.90** |

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78.7 төгрөг болж 2.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оноос аж ахуйн материалын үлдэгдэл өсөж, тусгай зориулалтын материал, хүнс, бичиг хэргийн материалын үлдэгдлүүд буурсантай холбоотой байна. Аймгийн Боловсрол соёлын газраас 0.4 сая төгрөгийн ариутгалын бодис үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Тайлант онд 29.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, 0.4 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй авч, нийт 29.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 27.1 сая төгрөгийн материал зарцуулж, аж ахуйн материалаас олон жил ашиглаж ашиглах боломжгүй, чанар байдлаа алдсан 2.8 сая төгрөгийн материалыг акталж, хүнсний материалаас 1.8 сая төгрөгийн материалыг аймгийн МХГ-ын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01/90 тоот албан даалгаварын дагуу устгалд оруулж, баримтжуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1919.1 сая төгрөг болж 269.8 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, акталсан хөрөнгийн зөрүүгээр өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8.1 сая төгрөгийн, УТХО, БШУЯ-наас үнэ төлбөргүй 294.5 сая төгрөгийн, нийт 302.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 19 тоот, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 63 тоот тогтоолуудаар 36.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгалд оруулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй, Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлтгүй гараагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1525.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 320.5 сая төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 26.5 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээ, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны ээлжит II хуралдааны 16 дугаар тогтоолоор тус сургуулийн төсвийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1033.2 сая, орон нутгийн төсвөөс 143.2 сая төгрөг нийтдээ 1176.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны Төсвийн сарын зохицуулсан хуваарь батлах тухай А/1093 тоот захирамжаар тус сургуулийн батлагдсан төсвийг 1225.9 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Энэ нь анх батлагдсан төсвөөс хоолны зардлаас 51.8 сая, үдийн цайны зардлаас 13.0 сая төгрөгөөр бууруулж, цалин, үр дүнгийн урамшууллын зардлыг 93.3 сая, НДШ-ийн зардлыг 12.6 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 4.0 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 4.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 49.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалин, урамшууллын зардлыг 93.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 12.6 сая төгрөгөөр дутуу суулгасантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1225.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1082.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 143.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төсвөөс 1082.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 143.2 сая төгрөг, нийт 1225.9 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1225.7 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна. Томилолтын зардлыг 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| № | Хөтөлбөр | Арга хэмжээ | Нэршил | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70802 | 70602 | Ерөнхий боловсрол | | | |
| 2 | | 80109 | ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 143,180.0 | 143,180.0 | - |
| 3 | | 81801 | үдийн цай хөтөлбөр | 17,082.5 | 17,082.5 | - |
| 4 | | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 137,453.1 | 147,453.1 | - |
| 5 | | 81834 | Боловсролын стандарт, сургалты | 681,837.6 | 681,606.4 | 231.2 |
| 6 | | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 246,381.4 | 246,381.4 | - |
| **Нийт дүн** | | | | **1,225,934.6** | **1,225,703.4** | **231.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Боловсролын газраас ариутгалын зардалд 0.5 сая, тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 4.3 сая, үнэлгээ тогтоох шалгалтын зардалд 0.3 сая нийтдээ 5.0 сая төгрөгийн  санхүүжилтийг бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 0.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний, 4.5 сая төгрөгийг хичээл практик үйлдвэрлэлийн зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 909.7 сая төгрөг, НДШ-ийн зардалд 122.8 сая төгрөг, халаалтын зардалд 138.0 сая төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 1.2 сая төгрөг, хоол, үдийн цайны зардалд 32.5 сая төгрөг нийтдээ 1204.2 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 1225.7 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 1204.2 сая төгрөгийг хасахад 21.5 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2.1 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс 0.2 сая төгрөгийн хэмнэж, 1.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1361.6 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1361.6 сая мэдээллийг хугацаанд ил тод байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 1.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч, зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Тус сургууль нь тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.9 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алтан сумын Ерөнхий боловсролын сургууль | 1 | 1.9 | | | | | 1 | 1.9 | | |